



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2022. 01. 27 № 07/433

танай _____-ны № 48 -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Монгол Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс
тавьсан асуулгын дагуу холбогдох мэдээллийг
хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт: 17 хуудастай.



Б.БАТЦЭЦЭГ

115220084

Гадаад харилцааны сайдын 2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 07/ дугаар албан бичгийн хавсралт



1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа, тэр дундаа гадаад худалдааны бодлого, Олон Улсын Байгууллагатай хийсэн гэрээ хэлэлцээрийн явцад тавих хяналтын асуудал хамаардаг учраас гадаад худалдааг эрчимжүүлэх, хөнгөвчлөх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар:

Манай улс өнгөрсөн 30 гаруй жилд эдийн засгаа либералчлах, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд томоохон амжилт олсон. Монгол Улсын гадаад худалдааны эргэлт цар тахлын амаргүй нөхцөл байдалд 2020 онд 12.8 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 7.5 тэрбум, импорт 5.3 тэрбум ам.доллар байсан бол 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны эргэлт 16.1 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 9.2 тэрбум, импорт 6.8 тэрбум ам.доллар хүрснээр экспортын дүн импортын дүнгээс 2.4 тэрбум ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа. Монгол Улсын гадаад худалдаа эдүгээ ДНБ-ий 130%-тай тэнцэх хэмжээнд хүрч, эдийн засагт чухал хувь нэмэр оруулж байна.

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын гишүүн болсноор бусад 164 гишүүн улстай тэгш эрхтэй худалдаа хийх, гадаад зах зээлд хөнгөлөлттэй буюу үндэстний нэн тааламжтай болон үндэсний нөхцөл эдлэх, олон талт худалдааны тогтолцоонд хамтын шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж бүрдсэн. ДХБ-ын олон талт худалдааны эрх зүйн орчин нь нэг талаас гишүүн улсад хатуу үүрэг хүлээлгэх боловч үндэсний хэмжээнд зах зээлээ хамгаалах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, хөгжиж буй орнуудад нэн тулгамдсан эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдлыг хангах, төлбөрийн тэнцлийн хэт алдагдлыг бууруулах боломжийг олгодог.

Монгол Улсын хувьд худалдааны нээлттэй, чөлөөт бодлого нь эдийн засгийн бусад салбаруудтай харьцуулахад уул уурхайн салбарт хөгжлийн илүү өргөн боломжийг нээж, аж үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн бусад салбарын нийт экспортод эзлэх хувийн жин чамлалттай байна.

Иймд тус яамнаас экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хөрөнгө оруулалт, санхүү татвар болон хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх; уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар экспортыг төрөлжүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөх, гадаад зах зээлийг тэлж, экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Энэ хүрээнд тус яамнаас ШХУ-ын Женев хотноо төвтэй Олон улсын худалдааны төвийн дэмжлэгтэйгээр 2019 онд боловсруулсан “Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг” баримт бичгийг хэрэгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдааны салбар түүний дотор мэдээлэл харилцаа холбооны технологи, аялал жуулчлал болон сэргээгдэх эрчим хүч, эрдсийн боловсруулалтыг экспорт, хөрөнгө оруулалтын чиглэлээр хөгжүүлэх нөөц боломжийг ашиглах чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улс ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт 2017 онд нэгдэж, хэлэлцээрийн 99 дэх гишүүн улс болсон. Энэхүү хэлэлцээр нь экспорт, импорт мөн дамжин өнгөрөх барааны урсгалыг саадгүй, шуурхай нэвтрүүлэх, мөн худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хил гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, чадавхыг бэхжүүлэх замаар худалдааны өртөг зардал, цаг хугацааг бууруулах зорилготой. Далайд гарцгүй, алслагдмал байршилтай Монгол Улсын хувьд худалдааг хөнгөвчлөх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь худалдааг дэмжих зөөлөн дэд бүтцийг бий болгож буй хэрэг юм.

ДХБ-ын судлаачдын тооцоолсноор тус хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлснээр далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд (ДГХБО)-ын гадаад худалдааны зардал 13.2%-15.5%-иар буурч, ДХБ-ын гишүүн орнуудын бараа экспортлох хугацаа дунджаар 2 өдрөөр, харин бараа импортлох хугацаа 1-1.5 өдрөөр тус тус багасч, экспорт, импортод зарцуулах хугацаа одоо байгаагаас 47%-иар хэмнэгдэнэ.

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт заасны дагуу хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, салбар дундын зохицуулалт хийх үүргийг хэрэгжүүлэх Гадаад харилцааны сайдаар ахлуулсан “Үндэсний хороо”-г Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 137 дугаар тогтоолын дагуу байгуулсан. Үндэсний хороо өнгөрсөн хугацаанд зургаан удаа хуралдаж “Худалдааг хөнгөвчлөх 2018-2022 Үндэсний хөтөч зураг”, мөн “Үндэсний хорооны стратеги төлөвлөгөө 2018-2022”-г баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хэлэлцээрээр хүлээсэн үүргээ манай улс 2026 он гэхэд бүрэн хэрэгжүүлсэн байх ёстой бөгөөд өнөөдрийн байдлаар хэлэлцээрийн биелэлт 56.3%-тай байна.

Тус хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах тоймтой ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Дэлхийн Банк Группийн дэмжлэгтэйгээр 2019 оноос “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” төслийг хэрэгжүүлж, 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр энэ санг хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус сан нь импорт, экспорт, дамжин өнгөрөх тээвэрт шаардагдах худалдаатай холбоотой бүх хууль тогтоомж, зохицуулалтын мэдээллийг агуулсан цахим хуудас юм.
- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 10.4-т гишүүд импорт, экспорт, эсхүл дамжуулан өнгөрүүлэхэд шаардлагатай баримт бичиг, өгөгдлийг худалдаа

эрхлэгчид нэг цэгээр дамжуулан холбогдох эрх бүхий байгууллага, яам агентлагт мэдүүлэх боломж бүхий нэг цонхны системийг бий болгох талаар заасан. Энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2016 оноос хэрэгжиж буй Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (RIBS)-ийн хүрээнд хил гаалийн хяналтын "Цахим нэг цонх"-ны системийг байгуулах бэлтгэлийг хангаж байна.

- Гадаад худалдааг хөнгөвчлөх, улмаар цахим худалдааны орчныг бүрдүүлэх зорилгоор НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ЭСКАП)-оос санаачилсан "Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай Ерөнхий хэлэлцээр"-т нэгдэн орох бэлтгэл ажлыг хангасан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Цаашид УИХ, Байнгын хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Цаасгүй худалдааг хөнгөвчлөх Ерөнхий хэлэлцээрийг хамтад нь үр дүнтэй хэрэгжүүлж чадвал Монгол Улсын худалдааны зардал 30 хувиар буурна гэсэн тооцоог хийсэн.
- ГХЯ-ны зүгээс худалдааг хөнгөвчлөх чиглэлээр олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улс НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас хэрэгжүүлдэг Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн үйл ажиллагааны явцыг хянах (Reform Tracker) төсөл, Хямралын үед худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааны бэлэн байдалд түргэвчилсэн үнэлгээ хийх (Rapid Scan) төслийг тус тус хэрэгжүүлж ажиллаж байна.

Мөн Үндэсний хороо худалдаанд зарцуулагдах цаг хугацаа, зардал, баримт бичгийн бүрдүүлэлт, хилийн хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, давхардал зэрэг гадаад худалдаанд тулгарч буй бодит асуудлуудыг хэлэлцэж, зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжтэй холбогдож тэдэнд тулгарч буй саад, бэрхшээлийн талаар судалгаа хийсэн. Гадаад худалдаа эрхлэгч нь экспорт, импорт, дамжин өнгөрүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан дүрэм, журам, стандартын шаардлагыг мөрдөхийн тулд олон тооны мэдээлэл, бичиг баримтыг эрх бүхий байгууллагуудад цахим болон цаасан маягаар бүрдүүлж өгч байна. Эдгээр давхардсан бичиг баримт, дагалдан гарах зардал нь хил, гааль, хяналтын зэрэг холбогдох байгууллага болон бизнесийн хүрээнийхэнд ихээхэн хүндрэл учруулж буй бөгөөд асуудлыг шийдэх нэг арга бол гадаад худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцогч талуудад стандартчилагдсан мэдээлэл, бичиг баримтыг нэгдсэн цахим орчинд төвлөрүүлэх "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-

ыг бий болгох явдал юм.

Цахим нэг цонх байгуулагдсанаар бизнес эрхлэгчид гадаад худалдаа хийхэд шаардагдах бичиг баримт, мэдээллийг нэг удаа, нэг цэгт бүрдүүлэх боломжтой болж, худалдаанд зарцуулах цаг болон зардлаа хэмнэх бүрэн боломжтой болно.

2. Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болж, түүний хэлэлцээрүүдэд нэгдэн орсноор манай улсын эдийн засагт ямар үр ашиг үзүүлсэн, ямар үүрэг амлалт хүлээсэн, тарифын болон бусад хөнгөлөлтийн талаар:

Монгол Улс 1997 онд ДХБ-ын гишүүн болсноор ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг хүлээж, “ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол”-д дурдсан шаталсан хугацаа бүхий үүрэг, амлалтыг авсан. Энэ үүрэг, амлалтын хүрээнд УИХ-аас 1996 оны 71 дүгээр тогтоолоор 5 заалт бүхий дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан. Үүнд:

1. Монгол Улсын хууль тогтоомжийг ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдэд нийцүүлэх;
 - Энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас дотоодын холбогдох хууль тогтоомжийг ДХБ-ын хэлэлцээрүүдэд нийцүүлж, гаалийн үйлчилгээг хялбаршуулах, худалдаа, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн;
2. Уругвайн үе шатны хэлэлцээний төгсгөлийн баримт бичгийг сурталчлах, яам, агентлагуудын ажилтнуудад зориулж сургалт зохион байгуулах;
 - Холбогдох яам, агентлагуудын ажилтнуудад зориулж ГХЯ-наас дээрх сургалт, семинарыг тогтмол зохион байгуулж байна;
3. ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдийн орчуулгыг хянаж эмхтгэл болгон хэвлэх;
 - Хэлэлцээрүүдийн орчуулгыг хянаж, 2007 онд Төрийн мэдээлэл сэтгүүл /Тусгай дугаарын VII, VIII боть/-д хэвлүүлсэн;
4. ДХБ-ын олон талт хэлэлцээрүүдийг хариуцан хэрэгжүүлэх, тэдгээрт заасан мэдээ, мэдээллийг тогтмол гаргаж байх;
 - Засгийн газрын 1997 оны 14 дүгээр тогтоолоор ДХБ-ын хэлэлцээрүүдийг хариуцан хэрэгжүүлэх яам, агентлагийн хуваарийг баталсан.

5. ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Гадаад харилцааны яамны орон тоо, зохион байгуулалтад холбогдох өөрчлөлт оруулах.

Мөн тус байгууллагын гишүүн улс өөрийн худалдааны бодлогоо 7 жил тутам ДХБ-аар хянуулах үүргийн дагуу Монгол Улсын худалдааны бодлогыг 2005, 2014, 2021 онд тус тус хянан хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

1990 оноос өмнө манай улсын нийт гадаад худалдааны эргэлтийн 90 хувийг Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (ЗХТЗ)-ийн гишүүн орнууд, үүнээс 79 хувийг зөвхөн ЗХУ-тай хийсэн худалдаа эзэлж байсан. ЭЗХТЗ 1991 онд татан буугдсанаар Монгол Улс дэлхийн бусад улс орнуудтай чөлөөт зах зээлийн зарчмаар худалдаа хийх, гадаад зах зээлд нэвтрэх нөхцөлөө сайжруулах шаардлага гарсан.

Ийнхүү ДХБ-ын гишүүн болсноор дэлхийн олон улс оронтой тэгш эрхтэй худалдаа хийх, олон талт худалдааны зарчим, журмын дагуу олон улсын худалдаанд оролцох эрх зүйн орчин бүрдэж, ДХБ-ын гишүүний хувьд дараах хөнгөлөлттэй нөхцөлийг эдлэх боломжтой болсон. Үүнд:

- ДХБ-ын гишүүн бүх улс орнуудтай нэн тааламжтай үндэсний нөхцөл (Most Favoured Nation)-өөр худалдаа хийх;
- ДХБ-ын гишүүн хөгжингүй орнуудын Хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдах буюу тарифын хөнгөлөлттэй нөхцөл эдлэх;
- ДХБ-ын хүрээнд явагдаж буй аливаа хэлэлцээнд хөгжиж буй гишүүн орны хувьд ялгавартай, илүү тааламжтай нөхцөл эдлэх;
- Хоёр талын худалдаанд тулгарч болох аливаа асуудалд олон талт худалдааны механизмыг ашиглах зэрэг болно.

Олон талт худалдааны механизмаар дамжуулан эдийн засгийн аюулгүй байдлаа бэхжүүлэх, хоёр хөрш болон гуравдагч хөршүүдтэй худалдааны тэнцвэртэй харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзнэ. Цаашид ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээрийн дагуу гишүүн орны хувьд хүлээсэн үүргээс гадна үндэсний хэмжээнд зах зээлээ хамгаалах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих бодлого хэрэгжүүлэх, эдийн засаг, хүнсний аюулгүй байдал, төлбөрийн тэнцлийн хэт алдагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх боломжийг зохистой ашиглах, гадаад худалдааны салбарын хүний нөөц, үйл ажиллагааны тогтвортой байдал, чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна.

3. Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр, мөн Европын Холбооны “GSP+” худалдааны хөнгөлөлтийн системд хамрагдсанаар бизнес эрхлэгчдэд ямар боломжийг олгосон, тухайлбал, хэдэн төрлийн барааг ямар татвар, тарифаар импортлох,

экспортлохоор зааснаас хэдийг эдгээр нөхцөлөөр гаргаж оруулж буй хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш улс хоорондын худалдааны эргэлт хэрхэн өссөн талаар;

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улс хоорондын хэлэлцээр (ЭЗТХ) нь 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. ЭЗТХ-ийг байгуулсан улс төрийн зорилго нь бүс нутгийн интеграцад нэгдэх, гуравдагч хөршийн бодлогыг баталгаажуулах, харин эдийн засгийн зорилго нь хоёр талын худалдааг нэмэгдүүлэх, японы хөрөнгө оруулалтыг татах, аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингээсэн экспортыг нэмэгдүүлэх, японы өндөр техник технологийг нэвтрүүлэх, валютын орлогыг нэмэгдүүлэх, японы тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах, худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулах зэрэг болно.

Манай хоёр улс Дэлхийн гаалийн байгууллагын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 38 бүлгийн нийт 1355 төрлийн бараа экспортолж, импортолдог. Үүнээс монголын тал Японы импортын 24 бүлгийн 1290 төрлийн барааны 96 орчим хувь, японы тал Монголын экспортын 14 бүлгийн 65 төрлийн барааны 100 хувийг импортын гаалийн тарифаас үе шаттайгаар чөлөөлөхөөр харилцан тохиролцсон. Чингэхдээ манай улс эдгээр импортын барааны гаалийн тарифын үнийн дүнгийн 50 хувийг (825 төрлийн бараа), харин Япон Улс 99,4 хувийг 60 төрлийн бараа) хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус шууд чөлөөлсөн болно.

Барааны төрлөөр авч үзвэл, БТКУС-ийн ангиллаар Монголын тал 97 бүлгийн 5700 орчим төрлийн бараа, Японы тал 97 бүлгийн 9300 орчим төрлийн барааны импортын гаалийн тарифыг бууруулахаар хэлэлцээ хийсэн. Чингэхдээ манай улс эдгээр импортын барааны гаалийн тарифын 59 хувийг (3429 төрлийн бараа), харин Япон Улс 86 хувийг (8000 төрлийн бараа) хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус шууд “тэг”-лэсэн.

Хоёр орны хоорондын худалдааны эргэлт 2019 онд 601,0 сая ам.долларт хүрч, хэлэлцээр байгуулахаас өмнөх 2015 онтой харьцуулахад 2 дахин өссөн дүнтэй байна. Гаалийн ерөнхий газрын 2021 оны статистик мэдээгээр хоёр орны хоорондын худалдааны эргэлт 470.8 ам.долларт хүрснээс экспорт 17.7 сая ам.доллар, импорт 453.1 сая ам.доллар байна.

Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр хэрэгжиж эхэлснээс хойш хоёр орны худалдааны эргэлт нэмэгдэж байгаа боловч нийт худалдааны 95 гаруй хувийг Японоос нийлүүлж буй импорт эзэлсэн хэвээр байна. Япон Улсаас импортолж буй барааны ихэнх хувийг суудлын автомашин, уул уурхайн хүнд даацын машин механизм, түүний сэлбэг хэрэгсэл эзэлж байгаа бол манай улсаас тус улсад экспортолж буй барааны ихэнх хувийг ноос ноолууран бүтээгдэхүүн,

хивс, хонины өлөн гэдэс, муур нохойн хоол, дайвар бүтээгдэхүүн; эсгий бүтээгдэхүүн, адууны хөлдөөсөн болон хатаасан мах, монгол гэр, хөнгөн цагаан хайлш, гоо сайхны бүтээгдэхүүн, зөгийн бал зэрэг нэр төрлийн бараа тус тус эзэлж байна

Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)-аас ЭЗТХ-ийн хүрээнд гаалийн татварын хөнгөлөлт эдлэх барааны гарал үүслийн гэрчилгээг олгодог. Танхимаас 2016 онд 318 ширхэг, 2017 онд 481 ширхэг, 2018 онд 800 ширхэг, 2019 онд 569 ширхэг, 2020 онд 409 ширхэг, 2021 онд 534 ширхэг гарал үүслийн гэрчилгээг олгожээ. Үүнд нийт 70 гаруй аж ахуйн нэгжийн 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн тогтмол экспортолсон.

Европын Холбоо (ЕХ) нь жижиг буурай, хөгжиж буй эмзэг эдийн засагтай, далайд гарцгүй орнуудад олгодог хөнгөлөлтийн ерөнхий систем (*General System of Preferences*-*"GSP+"*)-д Монгол Улс 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хамрагдан, гурван жил тутам сунгуулж ирлээ.

Тус хөнгөлөлтийн ерөнхий системд хүний эрхийг дээдэлдэг, хөдөлмөрийн суурь эрхүүдийг хангасан "тогтвортой хөгжил, сайн засаглал"-тай хөгжиж буй улс орнуудыг урамшуулж, 7200 нэр төрлийн барааг гаалийн татвараас чөлөөлсөн байдаг бөгөөд хүний эрх болон хөдөлмөрийн эрхийн тухай НҮБ, ОУХБ-ын 16 суурь конвенц, тогтвортой хөгжил, сайн засаглалтай холбоотой 11 конвенцид тус тус нэгдэн орсон байх шалгуурыг тавьж, хэрэгжилтийн тайланг тогтмол хянадаг болно.

Энэхүү хөнгөлөлтөд оёмол, сүлжмэл бүх төрлийн бүтээгдэхүүн, арьс ширэн бүтээгдэхүүн, үслэг эдлэл, мал амьтны гаралтай ноос ноолуур, ундаа, архи, модон эдлэл, электрон бараа, гутал, хивс, зэс зэрэг манай улсын экспортын ач холбогдол бүхий бараа, бүтээгдэхүүн хамрагддаг.

Хөнгөлөлтийн ерөнхий системийн үр нөлөөний статистикийг Европын Холбоо гаргадаг бөгөөд хамгийн сүүлийн үеийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хэвлэгдсэн¹. Уг статистикийн дагуу Монгол Улсын Европын Холбоонд хийсэн экспортын хэмжээ, мөн GSP+ хөнгөлөлтийн ашиглалт тогтвортой өсөж ирсэн байна. GSP+ хөнгөлөлтийн ашиглалт дунджаар 87 хувьтай² бөгөөд нэхмэл, сүлжмэлийн бүтээгдэхүүн хөнгөлөлтийн дийлэнх хувийг хүртсэн.

*Худалдааны хэмжээг сая еврогоор илэрхийлэв

2017	2018	2019
------	------	------

¹ https://trade.ec.europa.eu/doclib/docs/2020/february/tradoc_158640.pdf

² The EU Special Incentive Arrangement for Sustainable Development and Good Governance ('GSP+') assessment of Mongolia covering the period 2018 – 2019. SWD (2020) 23 final

МУ-аас ЕХ-нд хийсэн экспорт	GSP-д хамрагдах	Ашигласан хөнгөлөлт	Хөнгөлөлт ашигласан хувь	МУ-аас ЕХ-нд хийсэн экспорт	GSP-д хамрагдах	Ашигласан хөнгөлөлт	Хөнгөлөлт ашигласан хувь	МУ-аас ЕХ-нд хийсэн экспорт	GSP-д хамрагдах	Ашигласан хөнгөлөлт	Хөнгөлөлт ашигласан хувь
69,997	19,880	17,220	86.6%	72,601	17,906	16,461	91.9%	83,863	22,858	19,025	83.2%

Европын Холбооны “GSP+” Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хүрээнд ГХЯ, ГЕГ, МҮХАҮТ хамтран Европын Холбооны “Бүртгэгдсэн экспортлогчдын систем” (*The Registered Exporter System-REX*)-ийг хэрэгжүүлж байна. МҮХАҮТ аж ахуйн нэгжүүдийг “REX” цахим санд бүртгэх, бүртгэлийн санг хөтлөх ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлүүлсэн бөгөөд 2020 оны байдлаар 85 аж ахуйн нэгж уг системд бүртгүүлээд байна.

Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжсэн “Монгол Улсын худалдааг дэмжих /ТРАМ/” төсөл эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус экспортын чадамжтай бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд ГХЯ, МҮХАҮТ-тай хамтран экспортын чадамжтай мал, амьтны гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн, чацарганы тос, торомны ноос/сарлагийн хөөвөр, арьс ширэн бүтээгдэхүүний дөрвөн кластерыг хөгжүүлж тэдгээрийн бүтээгдэхүүнийг ЕХ-ны зах зээлд гаргаж эхлээд байна.

Түүнчлэн төслийн хүрээнд, ХБНГУ-ын Берлин хотод Монголын “Мэдээлэл, худалдааг дэмжих төв”-ийн үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сард эхлүүлэв. Тус төвөөр дамжуулан экспортын 4 кластерын 20 гаруй гишүүн аж ахуйн нэгжийн бараа, бүтээгдэхүүнийг ХБНГУ болон Европын хэрэглэгчдэд борлуулж байна.

4. Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрээр олгосон боломж, Европын Холбооноос олгож буй худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийг манай бизнес эрхлэгчид бүрэн дүүрэн ашиглаж чадаж байгаа эсэх, дотоодын эрх зүйн зохицуулалт, бодлогын хувьд болон практикт ямар хүндрэл бэрхшээл учирч буй, тухайлбал, дотоодын бараа бүтээгдэхүүнийг Японы болон Европын зах зээлд экспортлоход ямар саад бэрхшээлтэй тулгарч байгаа, эдгээр бэрхшээлийг шийдвэрлэх арга замын талаар;

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрээр барааны үнийн дүнгийн 90-ээс доошгүй хувьд хамаарах бараанд ногдуулах гаалийн тарифыг чөлөөлсөн бөгөөд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах олон улсын жишигт нийцсэн хэлэлцээр болсон гэж үздэг.

ЭЗТХ хэрэгжиж эхэлснээс хойш хоёр орны худалдааны эргэлт нэмэгдэж

байгаа боловч нийт худалдааны 95 гаруй хувийг Японоос нийлүүлж буй импорт эзэлсэн хэвээр байгаа нь хоёр улс нөөц бололцоогоо бүрэн ашиглахгүй байгаа тул хэлэлцээрийн ашиглалтыг сайжруулж үндэсний экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ГХЯ-наас МҮХАҮТ-тай хамтран тус хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн нэгж, компаниудад тулгарч буй хүндрэл бэрхшээл, санал, зарим нийтлэг асуудлыг айлын талд тавиад байна. Мөн 2022 онд Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Барааны худалдаа, Гарал үүсэл, хамтын ажиллагааны дэд хороог хуралдуулахаар төлөвлөж байна.

Хэлэлцээрийн дагуу Монгол Улсаас олон нэр төрлийн барааг Япон Улсад экспортлоход импортын барааны гаалийн тарифын хөнгөлөлттэй хувь хэмжээ эдлэх боломжийг бүрдүүлж өгсөн. Гэсэн хэдий ч манай өнөөдрийн үйлдвэрлэлийн хөгжил, экспортод гаргах барааны чанар, стандарт зэргээс шалтгаалан импортын хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх боломжийг Монголын худалдаачид тэр бүр ашиглаж чадахгүй байна. Цаашид томоохон төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн нөхцөлд ЭЗТХ-ийн дагуу Монгол Улсын нийт экспорт 2025 он гэхэд 47.8 сая ам.доллараар өсөхөөр тооцоолсон байдаг ч далайд гарцгүй Монгол Улсын хувьд Японы талын сонирхож байгаа барааг хэлэлцээрт тусгасан худалдааг хөнгөвчлөх, гаалийн хамтын ажиллагаа болон хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг зохицуулсан заалтын тусламжтай аль болох хямд тээврийн зардлаар экспортлох боломжийг эрэлхийлэх нь зүйтэй. Эхний ээлжид нэмүү өртөг шингэсэн, овор хэмжээ багатай, Японы зах зээлд эрэлт өндөртэй барааг экспортлох, улмаар дунд хугацаанд хөдөө аж ахуй, олборлох үйлдвэрлэлийн салбарыг тойрсон аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх боломжтой болох юм.

Мөн түүнчлэн, манай улсад бизнес эрхлэгчид гадаад зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортлоход дэмжлэг үзүүлдэг хэрэгжүүлэгч агентлаг байдаггүй. Өнөөдөр дэлхийн дийлэнх улс орон худалдаа, ялангуяа экспорт, хөрөнгө оруулалтыг дэмжих бие даасан бүтэц, агентлагтай байна. Бүс нутгийн хэмжээнд БНСУ-ын КОТРА, Япон Улсын ЖЕТРО, мөн Сингапур Улсын Enterprise Singapore зэрэг байгууллагыг сайн жишээгээр дурдаж болно. Эдгээр байгууллага нь үндэсний аж ахуйн нэгж, байгууллагууд тухай чөлөөт худалдааны хэлэлцээрийн давуу талыг ашиглахад дэмжлэг үзүүлдэг аж. Иймд экспортыг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах агентлагийг байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улс, Европын Холбоо хоорондын худалдааны нийт эргэлт Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 2020 оны нэгдүгээр сард Европын Холбооны гишүүнчлэлээс гарснаар худалдааны хэмжээ буурсан. Хоёр талын худалдааны эргэлт 2020 онд 576 сая ам.доллар буюу Монгол Улсын нийт худалдааны 4.4 хувийг эзэлж байсан, 2021 онд Европын Холбоотой хийсэн худалдааны эргэлт 766.5 сая ам.доллар болж өссөн байна. Энэ нь манай улсын 2021 оны нийт худалдааны 4.8 хувьтай тэнцлээ.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг төрөлжүүлэх, ялангуяа уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлд онцгой анхаарч, Засгийн газрын 2018 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ЕХ-ны зах зээлд Монголын уламжлалт ноос, ноолууран сүлжмэл эдлэл, хөдөө аж ахуйн гаралтай органик хүнсний бүтээгдэхүүн, арьс ширэн эдлэл, гоо сайхны бүтээгдэхүүнийг гаргах зорилгоор ГХЯ, Үндэсний хөгжлийн газар, МҮХАҮТ хамтран ХБНГУ-ын Берлин хотод Мэдээлэл, худалдааг дэмжих төвийг 2020 оны 12 дугаар сараас нээн ажиллаж байна. Тус төвөөр дамжуулан мал, амьтны гаралтай орц найрлага бүхий гоо сайхны бүтээгдэхүүн, чацарганын тос, сарлагийн хөөвөр, торомны ноосоор хийсэн эдлэл, арьс ширэн эдлэл зэрэг дөрвөн кластер бүтээгдэхүүнийг Европын хэрэглэгчдэд хүргэж, цахим худалдааны платформоор борлуулж байна.

ЕХ-ны GSP+ хөнгөлөлтийн ерөнхий систем нь манай улсын бизнесийн салбарт тодорхой үр ашиг үзүүлж байгаа боловч дотоодын үйлдвэрлэгчдийн хүчин чадал хязгаарлагдмал, үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүний чанар, стандартыг хангах, тээврийн зардлаас шалтгаалан ЕХ-ны зах зээлийн боломжуудыг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтвортой, банк санхүүгийн тогтолцоо нь жижиг, дунд бизнесийг бодитоор дэмжсэн нөхцөлд гадаадын хөрөнгө оруулалт болон дэвшилтэт технологийн дагуу өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гэж үзнэ.

5. Монгол Улс цаашид аль улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар төлөвлөж байгаа, Америкийн Нэгдсэн Улс болон өндөр хөгжилтэй бусад орон руу ямар бараа экспортлох талаар яриа хэлэлцээ хийж буй эсэх, аливаа улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээ хийх чадавх, дотоодын механизм хангалттай хэмжээнд бүрдсэн эсэх, цаашид анхаарах асуудлын талаар;

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-д “цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна”, 3.2.5.4-д “Бүс нутгийн болон олон улсын интеграцад нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.4.8-д “Улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна”, 4.4.9-д “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх, худалдааг хөнгөвчлөх замаар урт хугацаанд өрсөлдөх чадвар бүхий цөөхөн салбарт эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, экспортын боломж, зах зээлээ тэлэх бодлого явуулна”, 4.4.16-д “Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын

ажиллагааг өргөжүүлэх замаар худалдааг нэмэгдүүлнэ” зэрэг зорилтыг дэвшүүлсэн.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгааг гүйцэтгэсэн бөгөөд БНХАУ, Евразийн Эдийн Засгийн Холбоотой тус тус чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгааг хийж байна.

1. БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгаа хийх ажлын даалгаврыг 2016 оны 9 дүгээр сард айлын талтай баталгаажуулсан. Хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг 2017 онд 4 удаа хийж, мөн оны эцсээр судалгааны ажлыг эцэслэсэн. Улмаар судалгааны дүнг Гадаад харилцааны Сайдын зөвлөлийн хуралдаан болон Засгийн газрын хуралдаанд тус тус танилцуулсан. Хэлэлцээг эхлүүлэх нөхцөлийг тохирох саналтай байгаагаа манай талаас айлын талд тавьсан ба солонгосын тал одоогийн байдлаар ЭЗТХ байгуулах яриа хэлэлцээг бусад олон улстай явуулж байгаа тул ойрын хугацаанд Монгол Улстай хэлэлцээ хийх хүн хүчний нөөц боломж дутмаг байгаа тухай мэдэгдсэн. Хэлэлцээр байгуулах асуудлыг урагшлуулах зорилгоор 2021 онд талууд тус судалгааны холбогдох хэсэг, статистикийг шинэчилсэн бөгөөд МҮХАҮТ-тай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр хувийн хэвшил, холбогдох аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй зөвшилцөх уулзалт зохион байгуулсан.

Монгол, БНСУ-ын хамтарсан судалгааны багийн судалгааны ажлын “Зөвлөмж”-д хоёр улсын хооронд аж үйлдвэрийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь ач холбогдолтой, ЭЗТХ байгуулснаар хоёр орны худалдааны эргэлт 12.1-14 хувиар нэмэгдэн Монгол Улсын нийт баялгийн хэмжээ 0.09 хувиар, БНСУ-ын хувьд 0.002 хувиар тус тус өсөж, улмаар Монгол Улсын ДНБ 0.035 хувиар өсөх үр дүн гарна гэж тооцсон.

Хамтарсан судалгааны дүгнэлтэд Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүн болон ашигт малтмалын экспортын өсөлтөөс гадна үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох боловсруулсан эрдэс, металл, болон нэхмэл эдлэлийн экспорт нэмэгдэх, түүнчлэн, тээвэр логистик, барилгын салбар, санхүү бизнесийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх тодорхой зөвлөмжүүдийг дэвшүүлсэн.

2. Монгол Улс, БНХАУ хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар хамтарсан судалгаа хийх Монголын талын багийн бүрэлдэхүүн, удирдамжийг Гадаад харилцааны сайдын 2018 оны 6

дугаар сарын 04-ний өдрийн А/55 тоот тушаалаар батлуулсан. Хамтарсан судалгааны багийн анхдугаар уулзалтыг Улаанбаатар хотноо 2018 оны 09 дүгээр сарын 26-27-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтаар хамтарсан судалгааны ажлын даалгаврыг тохиролцсон. Хамтарсан судалгааны багийн хоёрдугаар уулзалтыг 2019 оны 2 дугаар сарын 14-15-ны өдөр Бээжин хотноо зохион байгуулсан. Уулзалтаар хамтарсан судалгааны ерөнхий хүрээ, бүтцийг тохирсон. Монгол Улс, БНХАУ-ын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгааны ажил үргэлжилж байгаа бөгөөд хоёр тал судалгааны дүнг нэгтгэх ажил хараахан дуусаагүй, хэлэлцээрийн үр нөлөөллийн талаарх талуудын байр суурь зөрүүтэй байгаа болно.

3. Манай улстай хил залгаа хэрэгжиж буй таван улсын 180 гаруй сая хүн ам бүхий нэгдмэл зах зээлийн бүтээн байгуулалтын геостратегийн төсөл болох Евразийн эдийн засгийн холбоо (ЭАЭЗХ)-г анх 2015 онд байгуулагдсан цагаас хамтын ажиллагааны механизм болох хамтарсан Ажлын хэсгийн хурлыг тогтмол зохион байгуулж, энэ хүрээнд бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх үүднээс ЭАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг бүх түвшинд илэрхийлж ирсний үр дүнд 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Евразийн эдийн засгийн комиссын зөвлөлөөс Монгол Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны Ажлын хэсгийг байгуулах шийдвэр гарсан.

Улмаар Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үр ашгийг судлах хамтарсан судалгааг эхлүүлж, өнгөрсөн 1 жил гаруй хугацаанд 7 бүлэг бүхий томоохон судалгааны тайланг бэлтгэх ажил эрчимтэй хийгдлээ. Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үр ашгийн хамтарсан судалгааг 2022 оны 1 дүгээр улиралд эцэслэж, судалгааны дүнд тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох болно. Харилцан ашигтай Чөлөөт худалдааны хэлэлцээрийн тусламжтайгаар хоёр талын бизнес эрхлэгчдэд тулгарч буй гаалийн тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулах, улмаар арилгахад чухал түлхэц үзүүлэх боломжтой гэж харж байна.

АНУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах саналыг Монгол Улсын Засгийн газрын зүгээс анх 2007 оны 3 дугаар сард Монгол-Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын зөвлөлийн 3 дугаар хуралдааны үеэр АНУ-ын талд тавьсан. АНУ-ын тал уг саналыг судлан үзээд хоёр орны хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахын өмнө “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын

асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр /Ил тод байдлын тухай хэлэлцээр/-ийг манай улстай байгуулах, ийнхүү байгуулсан хэлэлцээрийг бүрэн дүүрэн хэрэгжүүлснээр цаашид чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн. Талууд 2010 оны 9 дүгээр сард хэлэлцээг эхлүүлж, хэлэлцээрийг УИХ-аас 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталсан бөгөөд тус хэлэлцээр 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ч манай талаас хууль, тогтоомжийн төсөлд олон нийтээс санал авч, төсөлд тусгаж байх механизмыг бүрэн нэвтрүүлээгүй байна.

Бүс нутаг, олон талт болон хоёр талын эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдаа, гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалтын хэлэлцээрийн яриа хэлэлцээг мэргэшсэн баг хийж, гүйцэтгэдэг олон улсын жишгийн дагуу цаашид Монгол Улсад ашигтай худалдааны хэлэлцээрүүд байгуулахын тулд чөлөөт худалдааны хэлэлцээний үндэсний орон тооны баг байгуулж, чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна.

6. Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс болон бусад гуравдагч орны зах зээлд уул уурхайн бус хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн тухайлбал, малын гаралтай боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох чиглэлээр хийгдэж байгаа тодорхой ажил бий эсэх талаар;

Монгол Улс мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөл, шаардлага тохиролцох чиглэлээр 16 улс оронтой хамтран ажиллах гэрээ, Засгийн газар хоорондын 2 хэлэлцээрийг байгуулсан. Мөн мал эмнэлгийн гэрчилгээ 36, мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл 9, хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлага 3-ыг тус тус тохиролцсон.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас хятадын тал 2021 оны 6 дугаар сард Монгол Улсаас БНХАУ руу экспортолж буй мах, махан бүтээгдэхүүний гадаргуугаас коронавирус илэрсэн гэсэн үндэслэлээр, мөн тус улстай хил залгаа аймгуудад шүлхий өвчин дэгдсэн зэрэг шалтгаанаар манай улсын мах, махан бүтээгдэхүүний экспортыг айлын талаас тодорхойгүй хугацаагаар зогсоогоод байна. Махны экспортыг зогсоох шийдвэр гаргасан нь экспортын тоо хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад 35-45 хувь буурах үндэслэл болсон.

ГХЯ болон БНХАУ-д сууж буй Дипломат төлөөлөгчийн газрууд хоёр талын бараа бүтээгдэхүүний хорио цээр, баруун бүсийн бог малын мялзан өвчнийг хоригийг цуцлах, мах экспортлох хүсэлтэй аж ахуй нэгжид хийх шалгалтын хугацааг тохирох зэрэг экспортын асуудлаар удаа дараа айлын талтай холбогдох яриа хэлэлцээг хийж буй бөгөөд БНХАУ-ын холбогдох байгууллагаас тавьсан шаардлагын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн

хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газрын хамтарсан дотоодын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, Монгол Улсын хэмжээнд нийт 67 үйлдвэрт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүний хүрээнд айлын талын шаардлага хангаж буй 27 аж ахуйн нэгжийн мэдээлэл, тайланг БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт хүргүүлээд байна.

Түүнчлэн БНХАУ-ын талаас манай улсын гурил экспортлогч аж ахуйн нэгжүүдэд тавьсан шаардлагын дагуу дотоодын холбогдох аж ахуйн нэгжүүдэд хянан магадалгаа хийж, нийт 12 аж ахуйн нэгжийн мэдээлэл болон үхэр, хонь, ямааны тос, тосноос ялгасан үүрмэг зэрэг амьтны гаралтай хүнсний бус бүтээгдэхүүн экспортлох хүсэлт гаргасан үйл ажиллагаа явуулж буй нийт 6 аж ахуйн нэгжийн шаардлага хангасан тухай тайланг айлын талд 2021 оны 11 дүгээр сард тус тус хүргүүлсэн болно.

Түүнчлэн, Монгол Улс, БНХАУ хооронд байгуулах “Монгол Улсаас сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлохтой холбогдсон хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын тухай протокол”-ын төслийг хоёр талын холбогдох байгууллагууд эцэслэн тохиролцсоны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын БНХАУ-д хийх айлчлалын үеэр тус протоколд талууд гарын үсэг зурахаар бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

Монгол Улс, ОХУ-ын гишүүнчлэл бүхий Евразийн эдийн засгийн холбоо хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан Ажлын хэсгийн хүрээнд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан нөхцөлд уул уурхайн бус салбарын бараа бүтээгдэхүүний экспортод гарах өөрчлөлтийг судалж байна. Ялангуяа, тарифын бус саад тотгор, түүний дотор, мал эмнэлгийн эрүүл ахуй, хорио цээрийн зохицуулалтыг харилцан уялдуулснаар гарах эерэг нөлөөллийг хоёр тал хамтран судалж, хамтарсан тайлангийн төсөлд тусгахаар ажиллаж байна.

ГХЯ-ны зүгээс ОХУ-ын зах зээлд өөрийн улсын уул уурхай бус бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулахад анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ хүрээнд ГХЯ, Евразийн эдийн засгийн комисс болон МҮХАҮТ хамтран 2017 оноос хойш “Монгол Улс ба Евразийн эдийн холбоо” бизнес чуулга уулзалт, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аж ахуйн нэгжүүд хоорондын шууд хэлхээ холбоо, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх хүрээнд 2019 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д албан ёсны айлчлалын үеэр “Евразийн эдийн засгийн холбооны нэгдсэн зах зээлд бизнес эрхлэх нь” сэдэвт бизнес-форум, “Монголд үйлдвэрлэв” бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнг зохион байгуулсан. 2022 онд Монгол-Евразийн эдийн засгийн холбоо хоорондын бизнес форумыг зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.

7. Засгийн газраас бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцад нэгдэх асуудлаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар;

Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-т нэгдэж орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, 366 нэр төрлийн барааны хөнгөлөлтийн жагсаалтаар цуврал яриа хэлэлцээ хийсний дүнд нэгдэн орох нөхцөлөө 2018 оны 9 дүгээр сард эцэслэж хангасан. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганаар “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг хэлэлцэж дэмжсэн бөгөөд Монгол Улс хэлэлцээрийн 7 дахь гишүүн улс болоод байна. Хэлэлцээрийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар энэхүү хэлэлцээрт Монголоос гадна Бангладеш, БНХАУ, Энэтхэг, Лаос, БНСУ, Шри Ланка зэрэг 6 улс албан ёсоор нэгдээд байна. АНДХХ-ийн оролцогч талууд 4 удаагийн тарифын хэлэлцээ хийж нийт 10677 бараа бүтээгдэхүүний гаалийн тарифыг харилцан бууруулахаар тохирч, 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Тарифаас гадна гишүүн орнууд тарифын бус зохицуулалт, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх зэрэг асуудлаар хэлэлцээ хийхээр тохирсон.

АНДХХ-ийн гишүүн орнууд манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 70 орчим хувь, экспортын 90 орчим хувь, импортын 30 гаруй хувийг тус тус эзэлдэг. Монгол Улс уг хэлэлцээрт нэгдсэнээр үндэсний аж ахуйн нэгжүүд 2.9 тэрбум гаруй хэрэглэгчтэй, эдийн засгийн хурдацтай өсөлттэй АНДХХ-ийн зургаан гишүүн улс руу нийтдээ 10,667 нэр төрлийн бараанд 5-100 хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломж нээгдэхийн зэрэгцээ дэлхийн болон бүс нутгийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох, хөрөнгө оруулалт татахад илүү таатай нөхцөл бүрдэж байгаа юм.

Монгол Улс АНДХХ-ийн дараагийн үе шатны хэлэлцээнд оролцохтой холбогдуулан дээр дурдсан таван чиглэлээр хэлэлцээнд баримтлах байр суурийг боловсруулах зорилго бүхий шинжээчдийн багийг байгуулахаар төлөвлөж байна.

Цаашид манай улс Ази, Номхон далайн бүс нутгийн 15 орон буюу АСЕАН-ы гишүүн 10 орон /Камбож, Индонез, Лаос, Малайз, Мьянмар, Филиппин, Сингапур, Тайланд, Бруней, Вьетнам/ болон чөлөөт худалдааны хэлэлцээрийн түншлэгч 5 улс буюу Хятад, Япон, Өмнөд Солонгос, Австрали, Шинэ Зеланд зэрэг улс нэгдсэн “Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр”(RCEP)-т нэгдэх асуудлыг судалж байна.

Энэхүү хэлэлцээр нь гишүүн орнуудын хооронд худалдааны тарифыг харилцан бууруулах, үйлчилгээний худалдааг нэмэгдүүлэх зорилтоос гадна хөрөнгө оруулалт, эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа, цахим худалдаа, оюуны өмч, засгийн газрын худалдан авалт, өрсөлдөөн, худалдааг хөнгөвчлөх, тарифын бус саад тотгор, хамгаалалтын арга хэмжээ, жижиг, дунд үйлдвэр,

маргаан шийдвэрлэх механизм зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хамарч буй хэлэлцээр бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болоод байна.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцын үйл явцад, тэр дундаа Ази, Номхон далайн бүс нутагт Монгол Улсын оролцоог гүнзгийрүүлэх, өргөжүүлэх Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа-2050 зэрэг бодлогын баримт бичгүүдэд туссан зорилтын дагуу тус хэлэлцээрийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө, хэлэлцээрт нэгдэх боломжийн талаар мэргэжлийн судлаачдын дэмжлэгтэйгээр нарийвчилсан судалгаа хийхээр төлөвлөн ажиллаж байна.

8. Монгол Улсын гаалийн татвар 5 хувь байхад хөрш орнууд 20-40 хувийн гаалийн татвартай байгаа нь хөрш орнуудын зах зээлд бүтээгдэхүүн экспортлоход хүндрэл учруулж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар:

Манай улс ДХБ-ын гишүүн болсноор сонгино, сармис /15/, архи /40/, ликёр /40/, этилийн спирт /75/, шар айраг /25/, тамхи /40/ гэх мэт зарим цөөн нэр төрлийн бараанаас бусад бүх бараанд үндэсний нэн тааламжтай тарифын дээд хязгаарыг 20 хувиар ногдуулах үүрэг амлалт авсан. Гэвч ихэнх бараанд дунджаар 5-15 хувийн татвар ногдуулдаг. Иймд эдгээр барааны импортын татварын хувь хэмжээг манай улс ДХБ-д элсэн орохдоо авсан үүрэг амлалтын дээд хувь хэмжээнд хүргэх боломжтой.

Харин хөрш орнуудын зах зээлд бүтээгдэхүүн экспортлоход учирч буй хүндрэлийг дараах арга хэмжээг хэрэгжүүлж шийдвэрлэх боломжтой. Үүнд:

- Бараа бүтээгдэхүүний чанар, стандартыг импортлогч улсын, эсхүл олон улсын шаардлагад нийцүүлэх;
- Хөрш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах замаар экспортын зах зээлийг тэлэх, тухайн зах зээлд гарах хөнгөлөлттэй нөхцөл эдлэх, худалдаанд тулгарч буй саад тотгорыг бууруулах;
- Хөрш орнуудын Хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдах буюу тарифын хөнгөлөлттэй нөхцөл эдлэх боломжийг судлах;
- Бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцад нэгдэх;
- Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, давхардлыг арилгах, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах;

- Үйлдвэрлэл, экспортыг дэмжих хөгжлийн санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, арга хэрэгсэл бий болгох, олон улсын хөгжлийн санхүүжилтийн механизмуудыг ашиглах г.м.

Монголын экспортын бараа бүтээгдэхүүнийг ОХУ-ын зах зээлд нийлүүлэхэд тулгарч буй гол хүндрэл нь гаалийн татвараас гадна “нэмэгдсэн өртгийн албан татвар”, “онцгой албан татвар” болон бусад төлбөр, хураамжийг нэмж тооцдог явдал юм. Гаалийн татварыг чөлөөт худалдааны хэлэлцээрийн тусламжтайгаар бууруулах боломжтой хэдий ч эдгээр татвар, хураамжийг тус хэлэлцээрийн хүрээнд бууруулах боломжгүй юм.

Иймд экспортын бүтээгдэхүүнийг дээр дурдсан татвар, хураамжаас харилцан чөлөөлөх, эсхүл хөнгөлөх чиглэлээр хамтарсан судалгаа хийх саналыг ОХУ-д тавьсан бөгөөд айлын тал судалж үзэхээ илэрхийлээд байна.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ